

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/23/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .. Error! Bookmark not defined.	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	21
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	21
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 0/32
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шилжих үлдэгдлээр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас 53,240.9 мянган төгрөгийн зардлыг хөрөнгө оруулалтын шинж чанартай үйл ажиллагаанд зарцуулаагүй, шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татаж, дэд бүтэц бий болгосон 154,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг орлогод авч тайлагнаагүй, нийт 207,240.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотойгоор гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг нэвтрүүлэхээр "Ухаалаг засаглал" Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ хийж, 3,000.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж шинэчлэхээр Си Ти Эм хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж 3,500.0 мянган төгрөг төлж, урсгал зардлаар тайлагнасан байна.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

019020039

Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28 өдрийн А/193 захирамжийг үндэслэн, малын үүлдэр угсааг сайжруулахаар 46,000.0 мянган төгрөгөөр Сэлэнгэ үүлдрийн 22 бярууг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Өндөрширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар 2024 онд сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг болон ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.

Баяр наадмын талбайг цогцоор нь шинэчлэн барих 194,518.8 мянган төгрөгийн өртөгтэй тендерийн ажлыг Арцат алтай констракшин гүйцэтгэж, 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүлээн авч шаардлагатай нэмэлт ажлуудыг магадлашгүй ажлын зардалд тусган хийлгүүлж, ашиглалтад оруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,897,458.34	174,853,538.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	АВЛАГА	45,000.00	45,000.00
335	Бусад авлага	45,000.00	45,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	45,000.00	45,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,852,458.34	174,808,538.34
351	Түүхий эд материал	15,963,750.00	15,443,250.00
35110	Тусгай зориулалттай материал	15,963,750.00	15,443,250.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,946,000.00	10,725,000.00
354	Хангамжийн материал	57,882,708.34	66,420,288.34
35410	Бичиг хэргийн материал	2,135,600.00	2,185,100.00
35420	Аж ахуйн материал	20,985,723.90	27,475,903.90
35430	Сэлбэг хэрэгсэл	21,095,000.00	21,095,000.00
35440	Түлш, шатах тослох материал	357,300.00	655,200.00
35450	Барилгын засварын материал	1,645,000.00	3,345,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,664,084.44	11,664,084.44
35500	Биологийн хөрөнгө	7,720,000.00	7,720,000.00
35600	Мал амьтад	24,340,000.00	74,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,054,076,333.97	1,270,772,344.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,054,076,333.97	1,270,772,344.56
392	Биет хөрөнгө	1,037,185,303.97	1,254,174,324.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	769,753,596.00	1,063,858,579.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-181,650,892.83	-213,829,004.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	339,172,835.00	345,172,835.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-127,948,446.10	-174,105,401.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,448,850.00	109,144,350.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,439,571.78	-57,010,620.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,730,542.30	17,730,542.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,242,077.14	-11,611,121.50
39209	Зам, гүүрийн байгууламж	98,756,054.00	98,756,054.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-18,642,733.48	-20,878,667.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	240,357,192.00	255,357,192.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-136,110,044.00	-158,410,412.23
393	Биет бус хөрөнгө	16,891,030.00	16,598,020.00
39301	Програм хангамж	2,135,100.00	2,135,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,256,070.00	-1,549,080.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,012,000.00	16,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,161,973,792.31	1,445,625,882.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
413	Өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,161,973,792.31	1,445,625,882.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,161,973,792.31	1,445,625,882.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	425,137,525.38	425,137,525.38
51101	Өмч: - төрийн	425,137,525.38	425,137,525.38
512	Хуримтлагдсан үр дүн	539,324,609.80	822,976,700.39
51210	Өмнөх үеийн үр дүн	539,324,609.80	539,324,609.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	283,652,090.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,511,657.13	197,511,657.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,161,973,792.31	1,445,625,882.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	709,852,809.19	1,126,782,602.19
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,323,566.00	320,243,123.00
120	Нийтлэг татварын бус орлого	218,773,566.00	320,243,123.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,091,750.00	320,243,123.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,091,750.00	320,243,123.00
120009	Бусад орлого	166,681,816.00	00.00
122	Тусламжийн орлого	2,550,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,550,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,529,243.19	806,539,479.19
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,759,343.19	84,047,079.19
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,912,942.00	48,648,809.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,846,401.19	35,398,270.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	443,769,900.00	722,492,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	443,769,900.00	722,492,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	475,315,243.19	843,130,511.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,315,243.19	802,768,270.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,109,939.17	679,190,809.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,044,713.31	381,354,873.59
210101	Үндсэн цалин	161,283,484.49	260,181,019.50
210102	Нэмэгдэл	39,412,390.92	101,102,241.78
210104	Урамшуулал	4,785,926.90	14,643,192.40
210105	Гэрээт ажлын хөлс	562,911.00	5,428,419.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,537,003.26	47,071,778.30
210201	Тэтгэврийн даатгал	17,618,801.55	32,222,466.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,060,447.24	3,813,548.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,648,357.77	3,243,537.35
210204	Ажилгүйдлийн даатгал	372,423.24	695,634.99
210205	Эрүүл мэндийн даатгал	3,836,973.46	7,096,591.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,853,556.00	31,818,787.68
210301	Гэрэл, цахилгаан	2,959,260.00	4,890,787.68
210302	Түлш, халаалт	20,894,296.00	26,928,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,522,938.60	48,090,257.00
210401	Бичиг хэрэг	2,680,900.00	5,155,550.00
210402	Тээвэр, шатахуун	20,906,838.60	28,493,677.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,235,000.00	5,775,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,515,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,185,200.00	8,486,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,520,000.00	1,928,900.00
210604	Урсгал засвар	15,520,000.00	1,928,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,934,900.00	4,318,000.00
210701	Гадаад албан томилолт	118,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,816,900.00	4,318,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	28,020,466.00	3,678,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,737,976.00	2,612,005.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	361,550.00	253,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	371,940.00	282,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	117,000.00	99,000.00

2109:	Бараа үйлчилгээний бусад зардал	55,676,362.00	160,929,958.41
210901:	Бараа үйлчилгээний бусад зардал	55,676,362.00	37,825,486.00
210903:	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	123,104,472.41
213:	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,205,304.02	123,577,460.62
2132:	Бусад урсгал шилжүүлэг	22,692,400.00	52,488,280.00
213204:	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,153,200.00	51,658,280.00
213207:	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,541,200.00	00.00
213209:	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,998,000.00	830,000.00
2134:	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,512,904.02	71,089,180.62
213403:	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,512,904.02	71,089,180.62
22:	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	40,362,241.00
2200:	Дотоод эх үүсвэрээр	00.00	40,362,241.00
222001:	Тоног төхөөрөмж	00.00	40,362,241.00
3:	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	234,537,566.00	283,652,090.59
145:	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225:	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,245,033.77	00.00
225001:	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,245,033.77	00.00
4:	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,245,033.77	00.00
5:	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	229,292,532.23	283,652,090.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	488,529,243.2	806,539,479.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,529,243.2	806,539,479.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,759,343.2	84,047,079.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,912,942.0	48,648,809.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,846,401.2	35,398,270.2
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	443,769,900.0	722,492,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	443,769,900.0	722,492,400.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	464,455,543.2	676,508,483.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,455,543.2	676,508,483.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,250,239.2	551,231,022.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,044,713.3	381,354,873.6
210101	Үндсэн цалин	161,491,215.9	260,181,019.5
210102	Нэмэгдэл	39,401,466.7	101,102,241.8
210104	Урамшуулал	4,589,119.7	14,643,192.4
210105	Гэрээт ажлын хөлс	562,911.0	5,428,419.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,537,003.1	47,071,778.3
210201	Тэтгэврийн даатгал	17,585,200.7	32,222,466.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,068,847.2	3,813,548.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,665,157.8	3,243,537.4
210204	Ажилгүйдлийн даатгал	374,103.2	695,635.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,843,694.1	7,096,591.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,853,556.0	31,818,787.7
210301	Гэрэл, цахилгаан	3,241,456.0	4,890,787.7
210302	Түлш, халаалт	20,612,100.0	26,928,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,453,386.0	29,573,400.0
210401	Бичиг хэрэг	3,042,500.0	2,000,000.0

210402	Тээвэр, шатахуун	19,660,886.0	21,618,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,235,000.0	5,775,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,515,000.0	180,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,499,500.0	2,279,900.0
210604	Урсгал засвар	20,499,500.0	2,279,900.0
2107	Томилолт, зочны зардал	4,934,900.0	4,318,000.0
210702	Дотоод албан томилолт	4,934,900.0	4,318,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,336,866.2	4,124,505.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,054,376.2	3,058,255.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	361,550.0	253,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	371,940.0	282,050.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	117,000.0	99,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,590,314.6	50,689,778.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,590,314.6	50,689,778.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,205,304.0	125,277,460.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,692,400.0	54,188,280.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,153,200.0	53,358,280.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,541,200.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,998,000.0	830,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,512,904.0	71,089,180.6
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,512,904.0	71,089,180.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,073,700.0	130,030,996.0
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,073,700.0	130,030,996.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,073,700.0	130,030,996.0
2200	Дотоод эх үүсвэрээр	24,073,700.0	130,030,996.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	53,240,996.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,073,700.0	76,790,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-24,073,700.0	-130,030,996.0
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	207,420,800.23	148,903,731.94	00.00	781,462,057.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,137,525.38	207,420,800.23	148,903,731.94	00.00	781,462,057.55
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,863,185.23	00.00	-5,863,185.23
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	539,324,609.80	00.00	1,161,973,792.31
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	539,324,609.80	00.00	1,161,973,792.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	539,324,609.80	00.00	1,161,973,792.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	283,652,090.59	00.00	283,652,090.59
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,137,525.38	197,511,657.13	822,976,700.39	00.00	1,445,625,882.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	443,769,900.00	427,854,397.17	722,492,400.00	667,289,577.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,769,900.00	427,854,397.17	582,037,600.00	537,258,581.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,228,700.00	410,315,197.17	501,423,100.00	483,070,301.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,505,100.00	206,044,713.31	360,141,500.00	356,864,917.21
210101	Үндсэн цалин	166,704,200.00	161,491,215.92	280,180,100.00	257,441,509.18
210102	Нэмэгдэл	45,800,900.00	39,401,466.69	45,161,400.00	79,351,795.72
210104	Урамшуулал	00.00	4,589,119.70	00.00	14,643,192.40
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	562,911.00	34,800,000.00	5,428,419.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтг	28,688,200.00	25,537,003.11	45,017,700.00	44,087,131.99
210201	Тэтгэврийн даатгал	20,188,000.00	17,585,200.72	30,612,000.00	30,333,518.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,125,100.00	2,068,847.24	3,601,400.00	3,568,649.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,700,000.00	1,665,157.77	2,881,200.00	2,854,919.42
210204	Ажилгүйдлийн даатгал	425,000.00	374,103.24	720,300.00	653,618.55
210205	Эрүүл мэндийн даатгал	4,250,100.00	3,843,694.14	7,202,800.00	6,676,426.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,546,300.00	23,853,556.00	34,747,200.00	31,818,787.68
210301	Гэрэл, цахилгаан	3,161,400.00	3,241,456.00	3,793,600.00	4,890,787.68
210302	Түлш, халаалт	21,384,900.00	20,612,100.00	30,953,600.00	26,928,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,175,700.00	25,117,700.00	24,519,400.00	22,291,400.00
210401	Бичиг хэрэг	2,552,500.00	2,552,500.00	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,815,200.00	15,815,200.00	14,336,400.00	14,336,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,258,000.00	4,235,000.00	6,183,000.00	5,775,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устга	2,550,000.00	2,515,000.00	2,000,000.00	180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,500,000.00	20,499,500.00	2,300,000.00	2,279,900.00
210604	Урсгал засвар	20,500,000.00	20,499,500.00	2,300,000.00	2,279,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,962,100.00	4,934,900.00	4,318,000.00	4,318,000.00
210702	Дотоод албан томилолт	4,962,100.00	4,934,900.00	4,318,000.00	4,318,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,532,300.00	27,336,866.15	10,879,300.00	4,124,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	29,153,000.00	26,054,376.15	9,500,000.00	3,058,255.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	428,000.00	361,550.00	428,000.00	253,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,300.00	371,940.00	391,300.00	282,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	128,000.00	117,000.00	128,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,319,000.00	76,990,958.60	19,500,000.00	17,285,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,319,000.00	76,990,958.60	19,500,000.00	17,285,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,541,200.00	17,539,200.00	80,614,500.00	54,188,280.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,541,200.00	17,539,200.00	80,614,500.00	54,188,280.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	53,400,800.00	53,358,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,541,200.00	6,541,200.00	26,213,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,000,000.00	10,998,000.00	1,000,000.00	830,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	140,454,800.00	130,030,996.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	140,454,800.00	130,030,996.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	140,454,800.00	130,030,996.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	443,769,900.00	427,854,397.17	722,492,400.00	667,289,577.88
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	443,769,900.00	427,854,397.17	597,037,600.00	541,834,777.88
132001	Орон нутгийн төсвөөс	352,999,900.00	337,084,397.17	597,037,600.00	541,834,777.88
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,770,000.00	90,770,000.00	125,454,800.00	125,454,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	90,770,000.00	90,770,000.00	125,454,800.00	125,454,800.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	23	23
620001	Удирдах ажилтан	7	7	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	7	7
620003	Үйлчлэх ажилтан	9	9	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	23.00	23.00	23.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00	5.00	5.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	6.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,161,942.00	74,760,720.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,161,942.00	74,760,720.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,008,742.00	74,760,720.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	24,489,956.38
210101	Үндсэн цалин	00.00	2,739,510.32
210102	Нэмэгдэл	00.00	21,750,446.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	2,984,646.31
210201	Тэтгэврийн даатгал	00.00	1,888,948.03
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	244,899.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	388,617.93
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	42,016.44
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	420,164.34
2104	Хангамж, бараа материалын зардал	4,335,686.00	7,282,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,845,686.00	7,282,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,673,056.00	40,004,118.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,673,056.00	40,004,118.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,153,200.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,153,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,153,200.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,161,942.00	74,760,720.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,161,942.00	74,760,720.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,368,056.00	28,837,450.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,085,000.00	45,923,270.19
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргатай 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 25 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 91,7 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн Б/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 7 албан хаагчтайгаар баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлж сумын үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 24-ний 03/01 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283,652.1 мянган төгрөгөөр буюу 24,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	45.0	45.0	0.0
Бараа материал	107,852.5	174,808.5	66,956.1
Үндсэн хөрөнгө	1,054,076.3	1,270,772.3	216,696.0
Нийт хөрөнгө	1,161,973.8	1,445,625.9	283,652.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,161,973.8	1,445,625.9	283,652.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,161,973.8	1,445,625.9	283,652.1

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх онд үүссэн авлагын үлдэгдэл 45.0 мянган төгрөг барагдуулаагүй үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 174,808.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 66,956.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь улсын онцгой комиссоос 1,592.6 мянган төгрөгийн 632 литр шатахуун, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 46,000.0 мянган төгрөгийн 22 бяруу, малын үнийг Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний А/43 тушаалаар шинэчлэн тогтоож, мал амьтад дансанд нас дэвшилтийн орлогоор 9,640.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 216,696.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 25-ны А/355 дугаар захирамжийн дагуу УИХ-ын гишүүний хүлээлгэн өгсөн 5 зөөврийн компьютер, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 194,518.8 мянган төгрөгийн баяр наадмын талбайг Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/193 захирамжийг үндэслэн үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Ахуйн үйлчилгээний барилгын гадна фасад дээвэр засвар болон сантехникийн засварыг 57,086.1 мянган төгрөгийн сайжруулалтаар бүртгэсэн байна.

Төсвийн хөрөнгөөр 4 багийн Засаг даргын мотоцикл 6,000.0 мянган төгрөгөөр, цагдаагийн тусгай хэрэгсэл 5,000.0 мянган төгрөгөөр, хурдан морины төхөөрөмж 15,000.0 мянган төгрөгөөр, хүндэтгэлийн тайз 18,000.0 мянган төгрөгөөр, 4 хос арслан 2,500.0 мянган төгрөгөөр, ухаалаг дэлгэц 8,290.0 мянган төгрөгөөр, цомцог гэр 22,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 123,104.5 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,445,625.9 мянган төгрөг болж 283,652.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 465,971.1 мянган төгрөг, нийт зарлагыг 465,971.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 202,386.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 668,358.0 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 578,358.0 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 90,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 668,358.0 мянган төгрөгийг 54,134.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 722,492.4 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 597,037.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 125,454.8 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 55,202.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 722,492.4 мянган төгрөг буюу 92,4 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, бараа ажил үйлчилгээний зардлаас 18,352.8 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгогдоогүйгээс урсгал шилжүүлгийн зардлын 26,426.2 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 10,423.8 мянган төгрөг, нийт 55,202.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	372,802.7	359,428.6	13,374.1	96.4%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	39,150.0	38,826.2	323.8	99.2%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	67,970.4	67,349.8	620.6	99.1%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	80,614.5	54,188.3	26,426.2	67.2%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918-Бусад	140,454.8	130,031.0	10,423.8	92.6%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,783.7	216.3	95.7%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	9,500.0	7,502.0	1,998.0	79.0%
9	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	2,000.0	180.0	1,820.0	9.0%
	Дүн	722,492.4	667,289.6	55,202.8	92.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд зориулан 32,503.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/727, 769 тоот захирамжаар 15,300.0 мянган төгрөгийн дэмжлэг, статистикийн хэлтсээс малын тооллого хийхэд зориулан 845.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор өмнөх оны нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн орлого болон өвс тэжээл борлуулсан орлого 41,998.3 мянган төгрөг, нийт 90,647.1 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 27,474.6 мянган төгрөг, хүүхдийн дотуур байрны хоолны тогоонд 2,700.0 мянган төгрөг, гамшгийн үеийн онцгой комиссын үйл ажиллагаанд 2,628.8 мянган төгрөг, ЗДТГ-ын автомашины засвар үйлчилгээнд 5,300.0 мянган төгрөг, өмнөх оны нэмэлт санхүүжилтийг татан төвлөрүүлсэн актын төлбөрт 10,204.9 мянган төгрөг, шатахууны зардалд 7,282.0 мянган төгрөг, өвс тэжээл болон тээврийн зардалд 18,325.0 мянган төгрөг, нийт 74,760.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулаагүй үлдэгдэл 15,886.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр /

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 92.8 %	710,992.4	659,607.6
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 66.8 %	11,500.0	7,682.0

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 92,8 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 66,8 хувиар хэрэгжсэн нь 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 55,202.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хур хог хаягдал, орчны бохирдол арга хэмжээ 9 хувьтай хангалтгүй хэрэгжсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй 2 тендер, тендер шалгаруулалтын онцгой журмаар 9 тендерийг зарлаж, нэгдсэн хогийн цэгийг ландшафиллийн аргаар булаах, эрүүл мэндийн төвд суудлын автомашин авах, ахуйн үйлчилгээний байрны гадна фасад, дээврийн засвар болон сантехникийн засвар сайжруулалтын ажил, уурын зуухны гадна фасадыг засварлаж өвс тэжээлийн фонд болгох зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны төсвийн төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 597,037.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,955.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,716.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээнээс хэмнэгдсэн 55,202.8 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17, зарлагын 2 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийг хугацаандаа байршуулж, байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 153 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 98,7 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 03/32 тоотоор ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,204.1	1	3,204.1	100
Албан шаардлага	1	2,812.0	1	2,812.0	100
Зөвлөмж	2	23,920.0	2	23,920.0	100
Нийт дүн	4	29,936.4	4	29,936.4	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг нэвтрүүлэхээр “Ухаалаг засаглал” Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ хийж, 3,000.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж шинэчлэхээр Си Ти Эм хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж 3,500.0 мянган төгрөг төлж, нийт 3 цахим программын байнгын ажиллагаа, хөгжүүлэлт, ашиглалт, үр дүнгийн байдлыг үзэх, шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татах, дэд бүтцийн магистрал шугамыг бүртгэлд хэрхэн тусгасан байдлыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 290,493.3 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснээс, аудитын явцад 72,789.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 72,789.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, төсвийн татан төвлөрүүлсэн дүнгээр тохируулга хийгээгүй, нэмэлт санхүүжилтийн тайлан нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

1.Улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд 10,463.2 мянган төгрөг олгосон зөрчил байна

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1.Шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татах, дэд бүтэц бий болгох 154,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 60,000.0 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 94,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлээд хөрөнгийг орлогод авч тайлагнаагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулахтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх хөрөнгийн зардлаас /компьютер тоног төхөөрөмж/ 53,240.9 мянган төгрөгийг хөрөнгийн шинжгүй зардалд зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу төлөвлөж, зарцуулах

2. Бусад асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа 20 газраас 19 газар бүртгэлтэй байна. Газрын гэрчилгээний дугаарын дагуу, газрын хэмжээс, үнэлгээг тулгаж, данс бүртгэлд бүрэн аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд байх газрыг данс бүртгэлд бүрэн авах

3. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа 6 тээврийн хэрэгсэл ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

